Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2,730,929.9 мянган төгрөг болж 966,729.7 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн 966,729.7 мянган төгрөгийн өөрчлөлтөөс шалтгаалсан байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 579,707,6 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр, нийт зарлагыг 579,707.6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 96,590.6 мянган төгрөгөөр бууруулж 483,117.0 мянган төгрөгөөр анх батлагдсан ба тодотголоор 641,207.8 мянган төгрөг болгож 158,090.8 мянган төгрөгөөр өсгөн баталсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 6 арга хэмжээг санхүүжүүлэхээр 641,207.8 мянган төгрөг батлагдсанаас 636,845.5 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 636,845.5 мянган төгрөг буюу 99.3 хувьтай байгаа нь үндсэн үйл үйл ажиллагааны зардлаас 1,912.5 мянга, баг хорооны үйл хорооны үйл ажиллагааны зардлаас 1,996.8 мянган төгрөгийг тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 1 | 80801 үндсэн үйл ажиллагаа зардал | 461,352.9 | 459,440.4 | 1,912.5 | 99.6 |
| 2 | 80106 Баг хорооны үйл ажиллагааны зардал | 99,077.7 | 97,080.9 | 1,996.8 | 98.0 |
| 3 | 80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж | 31,997.2 | 31,647.2 | 350.0 | 98.9 |
| 4 | 81102 Орон нутгийн нөөц хөрөнгө | 28,000.0 | 27,993.4 | 6.6 | 100 |
| 5 | 81701 Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх зардал | 780.0 | 766.2 | 13.9 | 98.2 |
| 6 | 82212 Хур хог хаягдал, орчны бохирдол | 20,000.0 | 19,917.4 | 82.6 | 99.3 |
| | Нийт дүн | 641,207.8 | 636,845.5 | 4,362.3 | 99.3 |

Эх сурвалж: Төсвийн гүйцэтгэлийн тайлангаас

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Үндсэн үйл ажиллагааны зардлаас 523.6 мянга буюу 0.1 хувь, баг хорооны үйл ажиллагааны зардлаас 1,996.8 мянга буюу 2 хувь, орон нутгийн нөөц хөрөнгө хөрөнгө 6.6 мянга буюу 0.02 хувь, байгаль орчны хамгаалах нөхөн сэргээх зардал 13.9 мянга буюу 1.8 хувь, хур хаягдал, орчны бохирдлын зардлаас 82.6 мянга буюу 0.4 хувийг тус тус буцаан төвлөрүүлсэн байна.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансаар дараах орлого төвлөрсөн байна.

*Хүснэгт 3. Нэмэлт санхүүжилтийн орлого* */мян.төг/*

| д/д | Орлогын төрөл | Авсан санхүүжилт |
|---|---|---|
| 1 | Мал тооллоыгн зардал/Статистикийн хэлтэс/ | 1,045.6 |
| 2 | Усны төлбөр | 821.5 |
| 3 | Аймгийн ЗДТГ /Сургалтын шатахуун/ | 716.5 |
| 4 | Хамтарсан багийн зардал | 1,013.5 |
| 5 | Өмнөговь сумын ЗДТГ-аас Баянговь сумд отор нүүдэл хийж байгаа багт дэмжлэг | 5,000.0 |
| 6 | Тендерийн хураамж | 420.0 |
|  | Нийт орлогын дүн | 9,017.1 |

Эх сурвалж: Нэмэлт санхүүжилтийн дансны хуулга

Дээрх орлогыг зориулалтын дагуу зарцуулж 194.3 мянган төгрөгийг орон нутгийн орлогод төвлөрүүлсэн байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Баянговь сумын ЗДТГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Н.Бүнчинсүрэн гүйцэтгэж, ахлах аудитор М.Алтантуяа, Газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянговь сумын ЗДТГ нь 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 1/13 дугаар албан бичгээр ирүүлсэн.

2023 оны төсвийн хөрөнгийг захиран зарцуулах 1 дүгээр гарын үсгийг Д.Отгонжаргал, 2 дугаар гарын үсгийг нягтлан бодогч Д.Энхжаргал нар зурж хөрөнгийг захиран зарцуулжээ.

## 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр төсвийн гүйцэтгэлийн нийт зардлыг сонгож, материаллаг байдлын түвшин 1.5 хувиар тооцож материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 716,558.8 мянган төгрөгөөс тооцоход 10,748.4 мянган төгрөг байгаа ба гүйцэтгэлийн материаллаг байдлыг 70 хувиар буюу 7,523.9 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

## 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор 2023 оны гэрэл цахилгааны зардлыг 554.5 мянга, түлш халаалтын зардал 104.9 мянган төгрөгийг тус тус хэмнэсэн байна.

## 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус байгууллага нь 2023 онд 159 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 152 мэдээллийг хугацаанд нь байршуулсан, 2 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 5 мэдээллийг байршуулах хугацаа болоогүй байна.

Тайлант онд шилэн дансны цахим хуудаст цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 599,427.8 мянган төгрөгийн 29 гүйлгээ мэдээлэхээс 14,301.7 мянган төгрөгийн 11 гүйлгээ мэдээлээгүй байна.

Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 55,657.2 мянган төгрөгийн 4 гүйлгээ мэдээлэхээс бүрэн мэдээлсэн байна.

Аймгийн Санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудитын албанаас 2023 оны 4 дүгээр улирлын байдлаар шилэн дансны цахим хуудас хөтөлж мэдээллийг үнэн зөв, бодитой, иж бүрэн, ач холбогдолтой, тогтоосон хугацаанд, тогтмол байршуулж байгаа эсэхэд хяналт шалгалт хийсэн байна. Дээрх хяналт шалгалтаар Баянговь сумын ЗДТГ-ын шилэн дансны мэдээллийг шалгаж Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 11,460.0 мянган төгрөгийн 2 мэдээллийг байршуулаагүй талаар зөвлөмж өгсний дагуу нөхөн байршуулсан байна.

Харин бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрт 221,512.9 мянган төгрөгийн 15 мэдээллийг байршуулахаас Засаг дарга нөөц хөрөнгө зарцуулах 2 захирамжийн 9,580.9 мянга, халаалтын гэрээний 34,681.4 мянга, шатах, тослох материал нийлүүлэх гэрээний 23,608.1 мянган төгрөгийг тус тус мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", 6.4.5 дахь "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр", 6.4.8 дахь "бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр" гэсэн заалтыг зөрчсөн байна.

*Шийдвэрлэсэн нь*: Шилэн дансны хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т заасан мэдээлэл, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлага, бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрт хөрөнгө зарцуулах шийдвэрийг хугацаанд үнэн зөв мэдээлж байх албан шаардлагыг хүргүүлэв.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

#### 4.5.1 Завсрын аудитын талаар

Завсар үеийн аудитыг 2023 оны 10 сарын 20-ны өдрөөс 10 сарын 22 өдрүүдэд хийсэн бөгөөд цалин, НДШ-ийн нягтлан бодох бүртгэлийн бичилтийг буруу хийсэнтэй холбоотой залруулах бичилт хийх зөвлөмжийг хүргүүлж санхүүгийн тайланд залруулсан.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар 3,676.9 мянган төгрөгийн 3 алдаа, зөрчил илэрснээс 1,835.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, зөрчил арилгах 1 албан шаардлага, зөрчлийг давтан гаргахгүй байх 1,841.9 мянган төгрөгийн 1 зөвлөмж хүргүүлсэн ба Баянговь сумын ЗДТГ-ын 2023.05.22-ны өдрийн 75 тоот албан бичгээр хэрэгжилтийг тооцсон байна.

*Хүснэгт 4. Төлбөрийн акт,* албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Төлбөрийн акт | 1 | 1,835.0 | 1 | 1,835.0 | 100 |
| Албан шаардлага | 1 | 0 | 1 | 0 | 100 |
| Зөвлөмж | 1 | 1,841.9 | 1 | 1,841.9 | 100 |
| **Нийт дүн** | 3 | 3,676.9 | 3 | 3,676.9 | 100 |

Эх сурвалж: 2023 оны аудитын тайлангаас

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 45,253.5 мянган төгрөгийн зөрчил[1] илэрснээс, 250.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 45,003.5 мянган төгрөгийн 2 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв

### 5.1 Төлбөрийн акт

1. Оны эхэнд 250.0 мянган төгрөгийн цалингийн урьдчилгааны үлдэгдэлтэй байсан бөгөөд энэ нь ажлаас гарсан хүний урьдчилгаа тул тайлант хугацаанд барагдуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах; 6.4.8 дахь "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь**: Цалингийн урьдчилгааны үлдэгдэл 250.0 мянган төгрөгийг төсөв захирагчаар төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

### 5.2 Албан шаардлага

1. Тайлант онд 21215.1 мянган төгрөгийн сэлбэг хэрэгслийн зарлага гаргасан ба тухайн авто тээврийн хэрэгслийн ашиглалт, сэлбэг эд ангийг солихдоо байгууллагын өмч хамгаалах зөвлөл нь шийдвэр гаргаагүй байна

Энэ нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2018 оны 04 сарын 03-ны өдрийн 86 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Өмч хамгаалах зөвлөлийн үйл ажиллагааны нийтлэг журам"-ын 3.13-т " Өмч хамгаалах зөвлөл нь хуулийн этгээдийн тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн ашиглалт, сэлбэг эд ангийг солих, барилга байгууламжийн их засвар хийх тохиолдолд батлагдсан норм стандартыг мөрдүүлэх, барилгын болон техникийн хувийн хэрэгт нь баяжилт хийлгэх зэргээр хяналт тавьж ажиллана" гэсэн заалтыг зөрчсөн байна.

[1] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

**Шийдвэрлэсэн нь:** Байгууллагын өмч хамгаалах зөвлөл нь тээврийн хэрэгслийн сэлбэг, эд ангийг солихдоо батлагдсан норм стандартын дагуу тухай бүр дүгнэлт гаргаж зөрчлийг арилгах албан шаардлагыг хүргүүлэв.

2. Тайлант онд Засаг даргын нөөц хөрөнгөд 27,993.4 мянган төгрөг зарцуулснаас 23,788.4 мянган төгрөгийг шагнал урамшуулал, уралдаан тэмцээн, хүлээн авалтын зардал хавтгайруулан зарцуулсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.1-д "Зардал бууруулахад чиглэсэн арга хэмжээг энгийн ойлгомжтой, тууштай, өндөр сахилга баттайгаар зохион байгуулах", 15 дугаар зүйлийн 15.1-д " Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно",15.1.3-д "Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох", 15.1.5-д "Төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах" , Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 1.1. "Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргад хуулиар олгогдсон бүрэн эрхтэй зөрчилдөхгүй, урьдчилан төлөвлөж төсөвт тусгах боломжгүй байсны улмаас тухайн төсвийн жилийн дундуур зайлшгүй хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээ, зардлыг Засаг даргын нөөц хөрөнгө (цаашид "нөөц хөрөнгө" гэх)-өөс санхүүжүүлэх, гүйцэтгэлийг тайлагнахад энэ журмыг мөрдөнө", 2.1.5-т "Энэ журмын 2.1.1, 2.1.2-т зааснаас бусад Засаг дарга хуулиар олгогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбоотой урьдчилан төлөвлөж төсөвт тусгах боломжгүй байсан нэг удаагийн шинжтэй арга хэмжээ" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

*<u>Шийдвэрлэсэн нь</u>*: Засаг даргын нөөц хөрөнгөөс Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан журмын дагуу зарцуулж байх зөрчлийг арилгах албан шаардлагыг хүргүүлэв.

3. Тайлант онд шилэн дансны цахим хуудаст цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 599,427.8 мянган төгрөгийн 29 гүйлгээ мэдээлэхээс 14,301.7 мянган төгрөгийн 11 гүйлгээ мэдээлээгүй, бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрт 221,512.9 мянган төгрөгийн 15 мэдээллийг байршуулахаас Засаг дарга нөөц хөрөнгө зарцуулах 2 захирамжийн 9,580.9 мянга, халаалтын гэрээний 34,681.4 мянга, шатах, тослох материал нийлүүлэх гэрээний 23,608.1 мянган төгрөгийг тус тус мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", 6.4.5 дахь "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр", 6.4.8 дахь "бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр" гэсэн заалтыг зөрчсөн байна.

*<u>Шийдвэрлэсэн нь</u>*: Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг бүрэн байршуулж, зөрчлийг арилгах, цаашид зөрчлийг дахин давтан гаргахгүй байх

орхигдуулсан мэдээллийг байгууллагын шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээлэх албан шаардлагыг хүргүүлэв.

4.Тухайн байгууллагын санхүүгийн тайланд 12.434 м2 газар бүртгэлтэй байгаа бөгөөд Баянхонгор аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газраас ирүүлсэн судалгаанд 577084м2 газар бүртгэлтэй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйл, 13.7 “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” заалтыг зөрчсөн байна.

_Шийдвэрлэсэн нь_: Газрын бүртгэлтэй холбоотой зөрчлийг арилгах албан шаардлагыг хүргүүлэв.

Дээрх акт, албан шаардлагын биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2023 оны 05 дугаар сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(мянган төгрөг)

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Оны эхэнд 250.0 мянган төгрөгийн цалингийн урьдчилгааны үлдэгдэлтэй байсан бөгөөд энэ нь ажлаас гарсан хүний урьдчилгаа тул тайлант хугацаанд барагдуулаагүй байна. | 1 | 250.0 | 1 | 250.0 | - | - | - | - |
| Тайлант онд 21215.1 мянган төгрөгийн сэлбэг хэрэгслийн зарлага гаргасан ба тухайн авто тээврийн хэрэгслийн ашиглалт, сэлбэг эд ангийг солихдоо байгууллагын өмч хамгаалах зөвлөл нь шийдвэр гаргаагүй байна | 1 | 21,215.1 | | | 1 | 21,215.1 | - | - |
| Тухайн байгууллагын санхүүгийн тайланд 12.434 м2 газар бүртгэлтэй байгаа бөгөөд Баянхонгор аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газраас ирүүлсэн судалгаанд 577084м2 газар бүртгэлтэй байна. | 1 | 0 | | | 1 | 0 | | |
| Дүн | **3** | **21,465.1** | **1** | **250.0** | **2** | **21,215.1** | **0** | **0** |

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

(мянган төгрөг)

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Тайлант онд Засаг даргын нөөц хөрөнгөд 27,993.4 мянган төгрөг зарцуулснаас 23,788.4 мянган төгрөгийг шагнал урамшуулал, уралдаан тэмцээн, хүлээн авалтын зардал хавтгайруулан зарцуулсан байна. | 1 | 23,788.4 | | | 1 | 23,788.4 | | |
| Шилэн дансны тухай хуультай холбоотой зөрчил | | | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Тайлант онд шилэн дансны цахим хуудаст цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 599,427.8 мянган төгрөгийн 29 гүйлгээ мэдээлэхээс 14,301.7 мянган төгрөгийн 11 гүйлгээ мэдээлээгүй, бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрт 221,512.9 мянган төгрөгийн 15 мэдээллийг байршуулахаас Засаг дарга нөөц хөрөнгө зарцуулах 2 захирамжийн 9,580.9 мянга, халаалтын гэрээний 34,681.4 мянга, шатах, тослох материал нийлүүлэх гэрээний 23,608.1 мянган төгрөгийг тус тус мэдээлээгүй байна. | 1 | 82,172.1 | - | - | 1 | 82,172.1 | - | - |
| Дүн | 1 | 105,960.5 | | | 1 | 105,960.5 | 0 | - |

-----------oOo-----------

**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
**АКТ**

2024 оны 02 сарын 23 өдөр                Дугаар 29/А0570240/БНА-2024/203/НА-СТА-ТШЗ Номгон

ТӨЛБӨР БАРАГДУУЛАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянговь сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмнөх оны авлагын үлдэгдэл 250,000 (Хоёр зуун тавин мянган) төгрөгийн цалингийн урьдчилгааг барагдуулаагүй байна

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах; 6.4.8 дахь "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь “Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.3.3 дахь “Цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон”, 4.2.3.8 дахь “Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 2.1.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" гэснийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Цалингийн урьдчилгааны үлдэгдэл 250,000 (Хоёр зуун тавин мянган) төгрөгийг төсөв захирагчаар төлүүлж, Төрийн сан дахь 100030000947 тоот төгрөгийн дансанд төвлөрүүлэх.
2. Аудитаар тогтоосон төлбөрийн актыг бүрэн барагдуулж, нотлох баримтыг 2024 оны 03 дугаар сарын 25-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын

5050091

газарт[1] ирүүлэхийг Баянговь сумын Засаг даргын Тамгын газрын дарга Д.Отгонжаргал, нягтлан бодогч Б.Энхжаргал нарт даалгав[2],[3].

**ТӨЛБӨРИЙН АКТЫГ ТОГТООСОН[4]:**

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.МӨНХБАТ

АУДИТОР Н.БҮНЧИНСҮРЭН

6417143544
ВЮА0067 9007423

---

[1] Монгол Улс, Баянхонгор аймаг, Баянхонгор сум, Нутгийн удирдлагын ордон 3 давхар

[2] Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана"

[3] Монгол улсын ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 5.5 "Аудитад хамрагдагч нь аудитын тайлангийн төслийн өөрт холбогдох хэсэгтэй танилцах, санал өгөх, албан шаардлага, төлбөрийн акт, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн гэж үзвэл эрх бүхий албан тушаалтанд гомдол гаргах эрхтэй"

[4] Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно

**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
**АЛБАН ШААРДЛАГА**

2024 оны 02 сарын 22 өдөр Дугаар 52/А0570240/БПА-2024/203/НА-СТА-ТШЗ Номгон

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянговь сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд 21,215,100 (Хорин нэгэн сая хоёр зуун арван таван мянга нэг зуун) төгрөгийн сэлбэг хэрэгслийн зарлага гаргасан ба тухайн авто тээврийн хэрэгслийн ашиглалт, сэлбэг эд ангийг солихдоо байгууллагын өмч хамгаалах зөвлөл нь шийдвэр гаргаагүй байна.

Энэ нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2018 оны 04 сарын 03-ны өдрийн 86 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Өмч хамгаалах зөвлөлийн үйл ажиллагааны нийтлэг журам"-ын 3.13-т " Өмч хамгаалах зөвлөл нь хуулийн этгээдийн тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн ашиглалт, сэлбэг эд ангийг солих, барилга байгууламжийн их засвар хийх тохиолдолд батлагдсан норм стандартыг мөрдүүлэх, барилгын болон техникийн хувийн хэрэгт нь баяжилт хийлгэх зэргээр хяналт тавьж ажиллана" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11 дэх “хууль, тогтоомж гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Байгууллагын өмч хамгаалах зөвлөлөөр сольсон тээврийн хэрэгслийн сэлбэг, эд ангийн дүгнэлт гаргаж нотлох баримтыг FAS системд оруулж, нотлох

5040159

баримтыг 2024 оны 05 дүгээр сарын 30-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Баянговь сумын Засаг даргын Тамгын газрын дарга Д.Отгонжаргал, нягтлан бодогч Б.Энхжаргал нарт даалгав[1],[2].

**АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН[3]:**

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: Б.МӨНХБАТ

АУДИТОР: Н.БҮНЧИНСҮРЭН

---

[1] Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана."

[2] Монгол улсын ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 5.5 "Аудитад хамрагдагч нь аудитын тайлангийн төслийн өөрт холбогдох хэсэгтэй танилцах, санал өгөх, албан шаардлага, төлбөрийн акт, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн гэж үзвэл эрх бүхий албан тушаалтанд гомдол гаргах эрхтэй"

[3] Төрийн аудитын тухай хуулийн 42.1-т энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно

**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
**АЛБАН ШААРДЛАГА**

2024 оны 02 сарын 23 өдөр Дугаар 53/40570240/ТЛ-2024/203/НА-СТА-ТШЗ Номгон

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянговь сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд Засаг даргын нөөц хөрөнгөд 27,993.4 мянган төгрөг зарцуулснаас 23,788.4 мянган төгрөгийг шагнал урамшуулал, уралдаан тэмцээн, хүлээн авалтын зардал хавтгайруулан зарцуулсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.1-д "Зардал бууруулахад чиглэсэн арга хэмжээг энгийн ойлгомжтой, тууштай, өндөр сахилга баттайгаар зохион байгуулах", 15 дугаар зүйлийн 15.1-д " Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно",15.1.3-д "Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох", 15.1.5-д "Төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах", Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 1.1. "Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргад хуулиар олгогдсон бүрэн эрхтэй зөрчилдөхгүй, урьдчилан төлөвлөж төсөвт тусгах боломжгүй байсны улмаас тухайн төсвийн жилийн дундуур зайлшгүй хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээ, зардлыг Засаг даргын нөөц хөрөнгө (цаашид "нөөц хөрөнгө" гэх)-өөс санхүүжүүлэх, гүйцэтгэлийг тайлагнахад энэ журмыг мөрдөнө", 2.1.5-т "Энэ журмын 2.1.1, 2.1.2-т зааснаас бусад Засаг дарга хуулиар олгогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбоотой урьдчилан төлөвлөж төсөвт тусгах боломжгүй байсан нэг удаагийн шинжтэй арга хэмжээ" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

5040100

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11 дэх “хууль, тогтоомж гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Засаг даргын нөөц хөрөнгөөс Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан журмын дагуу зарцуулж байх зөрчлийг арилгаж нотлох баримтыг FAS системд оруулж, нотлох баримтыг 2024 оны 05 дүгээр сарын 30-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Баянговь сумын Засаг даргын Тамгын газрын дарга Д.Отгонжаргал, нягтлан бодогч Б.Энхжаргал нарт даалгав[1],[2].

**АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН[3]:**

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: Б.МӨНХБАТ

АУДИТОР: Н.БҮНЧИНСҮРЭН

6417143544
БЭ 90067 9007423

---

[1] Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 “Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана.”

[2] Монгол улсын ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 5.5 “Аудитад хамрагдагч нь аудитын тайлангийн төслийн өөрт холбогдох хэсэгтэй танилцах, санал өгөх, албан шаардлага, төлбөрийн акт, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн гэж үзвэл эрх бүхий албан тушаалтанд гомдол гаргах эрхтэй”

[3] Төрийн аудитын тухай хуулийн 42.1-т энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно